



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2008 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 80

Мандалговь

Хөрөнгө акталж худалдах тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3 дахь заалт, 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн 2.1.7 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсгийн 5.8.а заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:


Нэг: Адаацаг сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2008 онд ашиглалтанд орсон 1,910,000 /Нэг сая есөн зуун арван мянган/ төгрөгний анхны өртөгтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн Бага оврын тракторыг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 250,000 /Хоёр зуун тавин мянган / төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Адаацаг сумын Засаг даргын тамгын газрын дарга /Б.Уранцэцэг/-т даалгасугай.

Дөрөв: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100199